



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 68

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Эй Ар Би Си" ХХК-ийн гүйцэтгэсэн Баянговь сумын Соёлын төвийн барилгыг 2017.12.01-нд улсын комиссоор хүлээн авсан гэх боловч зарим өрөөнд болон шатны хэсэгт плита хийгдээгүй, дотор заслын ажил дутуу хийгдсэн, дотор цахилгааны ажил бүрэн хийгдэж дуусаагүй, гадна тохижилтын ажил дутуу хийгдсэн.

2. "Жамьян пайтан" ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэцогт сумын Хачин ламын сүмийг сэргээн засварлах ажлыг 2017.12.01-нд улсын комисст бүрэн хүлээлгэн өгсөн гэх боловч аудитаар очиж шалгахад гадна тохижилт, хайс хашааны ажил хийгдээгүй, камержуулалтын сервэр ирээгүй

3. Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн эмнэлгийн дотоод засварын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Базар дарь" ХХК санхүүжилтийн 60 хувийг авсан атлаа ажлыг бүрэн хийгээгүй зөрчлүүд илэрлээ.

Дээрх ажлууд дутуу хийгдсэн байхад Захиалагч ажлын гүйцэтгэлийг 100 хувь баталгаажуулан актаар хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4.3-т заасан "Захиалагч байгууллага ... ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна" Монгол улсын Иргэний хуулийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол

2518085

улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.5-д “Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Гэрээний хугацаанд хийгдээгүй 165.5 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлж улсын комиссоор хүлээн авч, ашиглалтад оруулах.

Хоёр. Зөрчлийг арилгаж, холбогдох нотлох баримтыг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ихбаяр, аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Алтангэрэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ӨГСӨН:	
АХЛАХ АУДИТОР	Б.ДОЛЖМАА
АУДИТОР	Б.АЗБАЯР
ЗӨВШӨӨРСӨН:	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА	Г.БАТЖАРГАЛ
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО	
ТӨЛӨВЛӨТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА	Д.ИХБАЯР
ГХБХБГ-ЫН ДАРГА	Д.АЛТАНГЭРЭЛ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 64

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Хорол констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн барилга ашиглалтын явцад нам даралтын зуух галлагааны үед бууддаг, тогоо нь цоорсон, барилгын агааржуулалтыг дагаж цан цохидог, нар тусдаггүй өрөөнд цан ихээр цохисноос мөөгөнцөр үүссэн, төрөх өрөөний ойролцоо бохирын цооног байршуулсан нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, мөн бохирын хоолой дотор байршуулсан халаах утас шатсанаас бохирын хоолой ашиглалтгүй болсон, холбооны шугам холболт хийгээгүйн улмаас ашиглах боломжгүй болсон.

2. Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлыг “Баян товгор” хоршоо гүйцэтгэсэн ба ашиглалтын явцад үндсэн барилга, өргөтгөл хоёрын залгаагаар дулаан алддагаас шалтгаалж өргөтгөл хийсэн өрөөнүүд хүйтэн, ус зайлуулах хоолой хийгээгүйгээс өргөтгөлийн залгаа руу ус орж цан цохидог зөрчил илэрсэн.

3. “Хорго групп” ХХК-ийн гүйцэтгэсэн Баян-Өндөр сумын сургуулийн барилгын дээвэр шуурганд зарим хэсгээр хуурсан.

4. “Базар дарь” ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэцогт сумын сургуулийн үүдний довжооны хэсгийн плита хагарсан, гадна пасад зарим хэсгээр хагарсан, технологийн ангид цонх цантаж, чийг их үүссэнээс мөөгөнцөрдөж, муухай үнэр гарч байгаагаас хичээллэх нөхцөлгүй, дотор зарим гэрэлтүүлэг шатсан, дотор таазны эмульс зарим хэсгээр хуурсан.

Дээрх нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19-т заасан “Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаа нь байгалийн болон давагдашгүй хүчин

2519087

зүйлийн нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д “... үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө”, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.4-т заасан “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг ..., барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Дээрх ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар дахин засварлуулж, зөрчлийг арилган, хариуг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ихбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР
ЗӨВШӨӨРСӨН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН ДАРГА
Г.БАТЖАРГАЛ
Д.ИХБАЯР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 72

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит, Гурванбулаг сумын дунд сургуулийн 2018.03.09-ний өдрийн №18 тоот албан бичгийн дагуу газар дээр нь очиж шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг 2016 онд “Элбата” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ашиглалтын явцад хаалганы нугас, цоож, бариул эвдэрсэн, хаалга нь хуучин хаалганы раманд дээр суурилуулсан, хаалганы амалгаа нурсан, паркетан шал зарим хэсгээрээ хөндийрсөн, цонхны гадна амалгаа хагарч унаснаас зай завсар их гарсан, дулаан их алддаг зэрэг зөрчил илэрлээ.

Дээрх нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19-т заасан “Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаа нь байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д “... үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө”, гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

2518103

Нэг. Дээрх ажлыг гүйцэтгэгч “Елбата” ХХК-аар хууль, журамд заасны дагуу дахин засварлуулж, зөрчлийг арилгуулах.

Хоёр. Зөрчлийг арилгаж, холбогдох нотлох баримтыг 2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Алтангэрэлд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН¹:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР
ЗӨВШӨӨРСӨН:
ГХБХБГ-ЫН ДАРГА
Д.АЛТАНГЭРЭЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас таавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.